АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
“МАЯА РАФЛЕС ГРУПП” ХХК

ШИФР:МРГ25/12

Тайлбар бичиг

ЗАХИРАЛ Б.БЯМБАДОРЖ

ИНЖЕНЕР Т.БАТСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ 2025

ТАЙЛБАР БИЧИГ

№	ГАРЧИГ	Хуудасны дугаар
1.	ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	2
	1.1 Ерөнхий	2
	1.2 Үндэслэл	2
	1.3 Зураг төсөл боловсруулахад мөрдсөн стандарт	2
	1.4 Зураг төслийн иж бүрдэл	2
	1.5 Төслийн танилцуулга	3
2.	Авто замын зурвасын инженер геологийн судалгаа	5
	2.1 Зам, цаг уур амьсгал	5
3.	Авто зам төлөвлөлт	8
	3.1 Хэвтээ төлөвлөлт	10
	3.2 Босоо төлөвлөлт	11
	3.3 Хөндлөн огтлол төлөвлөлт	12
	3.4 Авто зам, явган замын хашлага	14
	3.5 Явган хүний зам болон дугуйн замын төлөвлөлт	15
	3.6 Ус зайлуулах байгууламж	16
	3.7 Авто замын тоноглол	17
4.	Хучилтын хийц төсөлөлт	20
5.	Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа	25
6.	Ажлын тоо хэмжээ	29
7.	Хавсралтууд	32 - 41

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1 Ерөнхий

Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний "Маяа рафлес групп" ХХК нь Захиалагч Орхон аймгийн Засаг даргын тамгын газар" – ын 01/2025 дугаартай авто замын зураг төсөл боловсруулах ажлын далгавраар **"Орхон айсаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл боловсруулах ажил"** – ыг хийж гүйцэтгэв.

.2 Үндэслэл

- Орхон аймгийн хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилэн төлөвлөгөө

.3 Зураг төсөл боловсруулахад мөрдсөн стандарт

- "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-04-2016
- "Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт" БНбД 30 – 01 – 04
- "Авто замын гүүр ба хоолой " БНбД 32 – 02 – 03
- "Барилгын байгууламжийн инженерийн судлгааны нийтлэг үндэслэл" БНбД11-07-04
- "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11 – 07 – 04 – ийн II хэсэг инженер геодезийн ажил" БНбД 3.01.03 – 88
- "Автозамын тэмдэг, техникийн шаардлага" MNS 4596:2014
- "Автозамын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014
- "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм /БД 31 – 101 – 04/" барилгын дүрэм
- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS6056:2009

.4 Зураг төслийн иж бүрдэл

- Авто замын зураг төсөл
- Жишиг техникийн шаардлага
- Инженер геологийн судалгааны ажлын тайлан
- Геодези, байрзүйн зураглалын тайлан
- Мэдээлэл холбооны кабель шугам зөөн шилжүүлэх зураг төсөл, төсөв
- Авто замын гэрэлтүүлгийн зураг төсөл, төсөв

5. Төслийн танилцуулга

- **Төслийн нэр: Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11 дүгээр хорооллын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл**
- **Байршил:** Орхон аймаг, Баян-Өндөр сум

Төслийг боловсруулахад оролцсон байгууллага, хүмүүс:

Байгууллагын нэр	Гүйцэтгэсэн ажлын нэр	ИТА
"Маяа рафлес групп" ХХК	Авто замын зураг төсөл	Т.Батсүрэн /мэргэшсэн инженер/ Б.Бямбадорж /мэргэшсэн инженер/
"Маяа рафлес групп" ХХК	Авто замын төсөв	Т.Батсүрэн /мэргэшсэн төсөвчин/
"Лэнд тест" ХХК	Инженер-геологийн судалгааны дүгнэлт	Ц.Лхагвасүрэн /Мэргэшсэн инженер/ А.Оргилболд /Мэргэшсэн инженер/
"Лэнд тест" ХХК	Геодези, байрзүйн судалгааны тайлан	Б.Бямба-Очир /Инженер/ Б.Гантулга /Инженер/
"И энд Си дизайн" ХХК	Холбооны кабель шугам шилжүүлэх ажлын зураг төсөл, төсөв	Б.Одбаяр /Инженер/ Э.Мядагбадам /Инженер/ С.Энхжин /Мэргэшсэн төсөвчин/
"Хайтал Мегават"ХХК	Цахилгаан гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл, төсөв	Б.Гантөгс /Мэргэшсэн инженер/ Э.Амин-Эрдэнэ /Инженер/ А.Энхцэцэг /мэргэшсэн инженер/

Авто зам төлөвлөж буй трассын одоогийн байдал нь урьд өмнө нь ямар нэгэн зам барилгын ажил хийгдээгүй ердийн хөрсөөр байна. Орхон аймгийн хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу авто замын трасс сонгогдсон бөгөөд өөр ямар нэг хувилбар сонгоогүй болно. Авто замын трассын дагууд Орхон аймгийн ГХБХБГ, Орхон аймгийн хангагч байгууллагуудтай зөвшилцөж авто замыг төлөвлөв.

Одоогийн байдал





2. АВТО ЗАМЫН ЗУРВАСЫН ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

.1 Зам, цаг уур амьсгал

Авто замын төлөвлөж буй газар нь Монгол орны зам-уур амьсгалын бүсчлэлээр **IIA** буюу уулт-тал хээрийн дэд бүсэд хамаардаг.



Зураг – 2. Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэл

Энэ бүсийн зарим онцлог үзүүлэлтүүдийг доорхи байдлаар үзүүлэв.

Хүснэгт – 1. Улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
II A	25X-9XI 2.XI	27.III-27IV 26.III	137-163 150	10.Y-11VI 25.Y	49-65 57	6-16.IX 11.IX	110-141 126	43-53 48

Тайлбар:

- Өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуныхн намрын эхлэл, өвлийн эхлэл намрын дуусах хугацаа болно.

Хүснэгт – 2. Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур		
	жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
IIA	-0...-3	55-60	-45...-45	300-400	-3...-8	-23...-33	15...17

Тайлбар: -0^{0}C нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд, доод хязгаарыг авав.

Хүснэгт – 3. Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
IIA	10-20.X 15.X	1.V-10.IY 20.Y	195-200 197	1-20.IY 10.IV	1.YI-1.YII 15.YI	51-80 65

Хүснэгт – 4. Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүүд

Дэд бүс	Дулааны улирал *			Хүйтний улирал
	Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
IIA	20.IY	5.X	168	197

Тайлбар:

- Авто замын барилгын үйлдвэрлэлийн хүйтний улирлын эх нь дулааны улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулааны улирлын эх болдог

Хүснэгт – 5. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм (Hg баганын өндрөөр)	Харьцангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зун	Намар		
IIA	0.7-2.5	2-4	1-2	1-2	550-650	70-60

Хүснэгт – 6. Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Дэд бүс	Хүчилтөрөг-чийн нягт, г/см^3	Хувцас хунарын дулаан чанар, IO(хүндэвтэр ажлыг нөхцлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
		Өвлийн	Хавар,намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц
IIA	250-270	4.5-5.5	3.0-3.5	1.5-1.8	170-180	105-110	80-85

Хүснэгт – 7. Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
IIA	1.14	0.84	0.88	1.28	1.1

Хүснэгт – 8. Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIA	5.III-1IV (16.III)	24.X-22.XI (7.XI)	206-262 (234)

Хүснэгт – 9. Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIA	5.III-1IV (16.III)	24.X-22.XI (7.XI)	206-262 (234)

3. АВТО ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ

Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын баталсан “11-р хорооллын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл” боловсруулах ажлын даалгавраар “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016, 2А зэрэглэлийн зорчих хэсэг нь зааглагдаагүй, хөдөлгөөний 2 зурвастай хөдөө орон нутгийн хуримтлуулагч замаар төлөвлөв.

Төлөвлөж буй авто замын байршлын тойм зураг

Төлөвлөж буй авто замын трассын үзүүлэлт

№	Ажлын тодорхойлолт	Авто замын трассын үзүүлэлт
1	Замын зэрэг	2А зэрэглэлийн зорчих хэсэг нь зааглагдаагүй, хөдөлгөөний 2 зурвастай хөдөө нутгийн хуримтлуулагч зам
2	Хөдөлгөөний тооцоот хурд /км/цаг/, уулархаг	50
3	Трассын урт /км/	Төлөвлөж буй авто зам – 0,971
4	Тойруугийн тоо, ш	3
5	Хэвтээ муруйн хамгийн бага радиус	100
6	Хэвтээ муруйн хамгийн их радиус	463
7	Тойруугын нийт урт	454
8	Тойруугын замд эзэлэх хувь	46.7
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	6639
10	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	1411
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	2800
12	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	-
13	Дагуугийн хамгийн их налуу	8
14	Дагуугийн хамгийн их налуугийн урт	197
15	Зорчих хэсгийн хөндлөн хэвгий	2%
16	Зорчих хэсгийн өргөн	7
17	Хөвөөний хөндлөн хэвгий	4%
18	Хөвөөний өргөн	0.5м*2
19	Замын зурвас эгнээний тоо	2
20	Замын зурвас эгнээний өргөн	3.5
21	Ногоон байгууламжийн өргөн	1м*2
22	Авто замын хашлагын өргөн	0,5м*2 (L хашлага)
23	Явган хүний зам	2м*1
24	Дугуйн зам	2м*1
25	Замын зурвас эгнээний өргөн	100
26	Ф1.0 Дугуй хоолой	1

3.1.Төслийн авто замын хэвтээ төлөвлөлт

Төслийн авто зам нь хэвтээ төлөвлөтийн 15 өнцөгтэй бөгөөд хамгийн их эргэлтийн радиус нь 3000м, хамгийн бага радиус нь 600м болно. Хэвтээ төлөвлөлтийн өнцгийн оройн байрлал, муруйн элементүүдийг Хүснэгт-д үзүүлэв.

Төлөвлөж буй авто замын хэвтээ төлөвлөлтийн үзүүлэлт

Элементүүдийн нэр	Элементүүдийн нэр				Элементүүдийн нэр	Длина элемента, м	Элементүүдийн нэр	
	пикет	+	X	Y			зүүн	баруун
Шулуун	0	0.000	5431464.020	429320.076	—	3.46		
Тойрог	0	3.460	5431467.220	429321.394	100	45.29	25° 56' 51"	
Шулуун	0	48.750	5431511.516	429328.743	—	69.82		
Тойрог	1	18.570	5431581.201	429324.415	463,13	43.00		5° 19' 11"
Шулуун	1	61.570	5431624.180	429323.744	—	66.15		
Тойрог	2	27.720	5431690.298	429325.782	300	289.62		55° 18' 50"
Шулуун	5	17.340	5431932.883	429462.596	—	454.04		

Авто замын тэнхлэгийн координат

ПК+	X, м	Y, м	Z, м
0+00,000	5431464.020	429320.076	1396.400
0+03,461	5431467.220	429321.394	1396.515
0+20,000	5431482.962	429326.405	1397.098
0+40,000	5431502.772	429328.903	1397.884
0+48,748	5431511.516	429328.743	1398.271
0+60,000	5431522.746	429328.045	1398.806
0+80,000	5431542.708	429326.805	1399.863
1+00,000	5431562.669	429325.566	1401.054
1+18,568	5431581.201	429324.415	1402.281
1+20,000	5431582.631	429324.328	1402.381
1+40,000	5431602.615	429323.581	1403.842
1+60,000	5431622.613	429323.698	1405.424
1+61,567	5431624.180	429323.744	1405.549
1+80,000	5431642.604	429324.312	1407.024
2+00,000	5431662.595	429324.928	1408.624
2+20,000	5431682.585	429325.544	1410.225
2+27,716	5431690.298	429325.782	1410.842

2+40,000	5431702.564	429326.411	1411.825
2+60,000	5431722.450	429328.509	1413.425
2+80,000	5431742.152	429331.926	1415.025
3+00,000	5431761.583	429336.649	1416.625
3+20,000	5431780.656	429342.656	1418.225
3+40,000	5431799.286	429349.919	1419.826
3+60,000	5431817.391	429358.408	1421.371
3+80,000	5431834.891	429368.084	1422.645
4+00,000	5431851.707	429378.904	1423.628
4+20,000	5431867.764	429390.821	1424.318
4+40,000	5431882.993	429403.780	1424.716
4+60,000	5431897.324	429417.726	1424.823
4+80,000	5431910.694	429432.595	1424.637

3.2 Босоо төлөвлөлт

Төлөвлөж буй замын дагуу төлөвлөлтийн хамгийн их болон бага налууг "Авто зам төсөллөх" ЗЗБНБД-004-2016 нормын дагуу төлөвлөлтийг хийв. Дагуу төлөвлөлтийн өгөгдлийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт – 29. Босоо муруйн төлөвлөлтийн элементүүд

Эхлэл, ПК	Төгсгөл, ПК	Радиус, м	Үндсэн налуу, ‰	Эхлэлийн налуу, ‰	Төгсгөлийн налуу, ‰	Шулууны урт, м
0+00,000	0+16,592		35			16.59
0+16,592	1+50,534	-2963.16		35	80	133.94
1+50,534	3+47,699		80			197.17
3+47,699	4+97,430	1369.61		80	-29	149.73
4+97,430	7+38,753		-29			241.32
7+38,753	8+34,964	4452.09		-29	-51	96.21
8+34,964	9+32,800		-51			97.84
9+32,800	9+63,253	-5304.71		-51	-45	30.45
9+63,253	9+71,379		-45			8.13

3.3 Хөндлөн огтлолын төлөвлөлт

Төлөвлөж буй замын элементүүдийг “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016 норм дүрмийн дэд зүйл 10.2.4-д заасны дагуу хөдөлгөөний зурвасын өргөнийг төлөвлөв. Хучилтын хийцийг инженер-геологийн судалгаа, хучилтын хийцийн тайланд үндэслэсэн.

Нэг маягийн хөндлөн огтлол

- Зорчих хэсгийн өргөн – 7.0м /эгнээний тоо – 2, нэг зурвасын өргөн – 3.5м, хэвгий 2 тал руугаа – 2%/
- Ногоон байгууламж – 1м / хоёр талдаа /
- Явган хүний зам – 2м / нэг талдаа, хэвгий 2% /
- Дугуйн зам – 2м / нэг талдаа, хэвгий 2% /
- Хайрган хөвөө – 0.5м / хэвгий 4% /
- Нийт далангийн өргөн – 11.0м

Хучилтын хийцийн зузаан:

- Өнгө асфальтбетон хучилт – 3см
- Суурь асфальтбетон хучилт – 4см
- Буталсан чулуун суурь – 20см
- Суурийн доод үе – 20см
- Хөлдөлтөөс хамгаалах үе – 30см



Нэг маягийн хөндлөн огтлол /далантай үед/



Нэг маягийн хөндлөн огтлол /хагас далан, хагас ухмалтай үед/



Нэг маягийн хөндлөн огтлол /ухмалтай үед/

Нэг маягийн хөндлөн огтлол /хажуу налуу бэхэлгээтэй далан, шуудууг үзүүлэв/

ХӨНДЛӨН ОГТЛОЛ 1



3.4 Авто зам, явган замын хашлага

Төлөвлөж буй замын зорчих хэсгийн усыг нэг хэвгийгээр зайлуулахаар төлөвлөсөн тул авто замын 1000x250/120x500мм хэмжээтэй L хэлбэрийн хашлага төлөвлөсөн. Авто зам шулуун хэсэг 1000x250/120x500мм хэмжээтэй L хэлбэрийн хашлага, муруй хэсэг 1000x250/130x500 хэмжээтэй L хэлбэрийн хашлага, гарцан дээр налуу, намхан 1000x130/120x500 хэмжээтэй L хэлбэрийн намхан хашлагуудыг тавина. Явган хүний замын захад 80x200x500мм-ийн жижиг хашлагыг босоогоор нь тавина.

3.5 Явган хүний зам болон дугуйн зам

Явган хүний зам болон дугуйн замыг 5см зузаантай асфальтбетон хучилттайгаар хийнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч хавтанг явган замыг голлуулж термопластик будгаар зориулалтын машинаар нэг үеэр хийнэ. Дугуйн замын тэмдэглэгээг мөн адил термопластик будгаар зориулалтын машинаар хучилтын ирмэгээс 10см зайд будаж тэмдэглэнэ.

Явган хүний замаар зорчигч нь энгийн зорчигчид байхаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, хүүхдүүд, тэрэг түрсэн иргэд байна. Тиймээс явган хүний замыг аль болох бүгдэд хүртээмжтэй, саадгүй байх талаас бодолцон барилгын ажлыг хийнэ. Явган замын гарцны уналтыг стандарт норм дүрмийн дагуу 1:10-тай байхаар төлөвлөв.



Харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч хавтан: Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан хавтан нь чиглүүлэгч болон анхааруулах гэсэн 2 төрөл байна. Хөтөч хавтан гэж харааны бэрхшээлтэй иргэд явган хүний замаар зорчихдоо таягаар дамжуулан хүрэлцэх мэдрэхүйгээрээ мэдэрч чиглэлээ баримжаалан явах зориулалттай товгор хээтэй хавтанг нэрлэх ба анхааруулах хавтан, чиглүүлэгч хавтан гэсэ н төрлүүд байдаг.

Анхааруулах хавтан: Анхааруулах хавтанг гарц, явган зорчигчийн хүлээж зогсох цэг, очих цэгт таарах салаа замыг зааж өгөх болон замд таарах саадыг мэдээлж чиглүүлэгч хавтан руу шилжих, уулзвар, муруй хэсэгт суурилуулан чиглэл өөрчлөгдөхийг анхааруулахад ашиглана. Явган хүний гарцан дээр анхааруулах хавтанг хийж өгнө.

Чиглүүлэгч хавтан: Чиглүүлэгч хавтан нь салаа зам, явган зорчигчийн хүлээж зогсох цэг, анхааруулах хавтанг үргэлжлүүлэн явах чиглэлийг мэдээлэх зориулалтаар явган хүний зам дагуу үргэлжлүүлэн мөн хэсэгчлэн суурилуулж чиглэл заах хүрээнд ашигладаг.



Нэгж : мм

Тэмдэглэгээ	Хэмжээ	Хүлцэх алдаа
a	12	+1.5
a'	a+10	
b	55~60*	
c	5	+1.0

Анхааруулах хавтан



Нэгж : мм

Тэмдэглэгээ	Хэмжээ	Хүлцэх алдаа
a	17	+1.5
a'	a+10	
b	75	
c	5	+1.0
d	270	
d'	d+10	

Чиглүүлэгч хавтан

3.6 Ус зайлуулах байгууламж

Төслийн талбайн орчны гадаргуугийн усыг зайлуулж, авто замын хэвийн ажиллагааг хангах зорилгоор нийт 1 байрлалдт Ф1.0 төмөрбетон хоолой төлөвлөж зураг төсөлд тусгалаа.

Ус зайлуулах байгууламжийн овор хэмжээ

№	Байрлал	F	$Q_{1\%}$	Хиймэл байгууламжийн төрөл	Тооцоот өнгөрөөх чадвар (м3/сек)
		($км^2$)	($м^3$/сек)		
1	0+029.10	0.921	1.653	0.054	1.742

Төлөвлөж буй Ф1.0х1 төмөрбетон дугуй хоолой





3.7 Авто замын тохижилт, тоноглол

Авто замд чиглүүлэх хэрэгслүүд техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014, 124 ширхэг босоо тэмдэг техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2013, 1232.27 м2 хэвтээ тэмдэглэл техникийн ерөнхий шаардлага MNS 4759:2013 стандарт норм дүрмийг баримтлан төлөвлөв. Авто замын босоо тэмдгүүдийг бетонон суурьтай төлөвлөв. Уулзваруудын өмнө зам тавьж өгөх, огцом өгсүүр, огцом уруу, анхааруулах болон явган хүний замын тэмдгүүдийг тавьсан. Авто замын аюултай хэсгүүдэд мөн зогс тэмдгийн өмнө 1.1 тэмдэглэгээг, ойртох хэсэгт 1.6 тэмдэглэгээг, үлдсэн хэсгүүдэд эгнээг тусгаарлах 1.5 тэмдэглэгээг, уулзвар дээр эгнээний хилийг 1.7 тэмдэглэгээ, орохыг хориглох хэсэгт 1.15.а тэмдэглэгээ, авто замын захыг 1.2 тэмдэглэгээ зэргийг байрлуулсан.

ЗАМЫН БОСООО ТЭМДЭГ

	Тэмдэг	Тэмдэгний дугаар	Тоо ширхэг
Авто зам			
Сэрэмжлүүлэх тэмдэг		3.4 Зам тойрч явах	5
		3.11 Гол зам	2
		3.3 Туслах зам нэмэгдэх баруун	1
Чиглүүлэх тэмдэг		5.19.а,б Явган хүний гарц	10
Анхааруулах тэмдэг		1.8а Өгсөх эгзэгт	2
		1.10 Эргэц уруу	1
		1.11 Өгсөх эгзэгт	1
Хориглох тэмдэг	2.1	2.1 Орох хориотой	1
Зөвшөөрөх тэмдэг		4.2.б Баруун дээд эргэн тойрон гарах	2
		4.2.в Зүүн талаар тойрон гарах	1
		7.13 Зүүн талаар тойрон гарах	1
		Нийт	30

ЗАМЫН ХЭВТЭЭ ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ҮРТ

№	Тэмдэглэгээний төрөл	Нийт урт м	Нийт м2
1	Дугаар-1.1	595	89.25
2	Дугаар-1.5	240.75	36.1
3	Дугаар-1.11	52	20.8
4	Дугаар-1.13	226	90.4
5	Дугаар-1.6	60	9
6	Дугаар-1.17	-	2.2
7	Дугаар-1.17	-	8
	Нийт	1173.75	255.75

ЗАМЫН ХЭВТЭЭ ТЭМДЭГЛЭГЭЭ

№	Хэвтээ дугаар хэмжээ	Эскиз
1.1		Замын хөдөлгөөнийг хоёроор хуваах хөдөлгөөний хэлбэлзэлтэй тэмдэг
1.5	1м 1м 1м 1м	Замын хөдөлгөөнийг
1.11		Зогсоолт
1.13.а		Явган хүний гарц
1.6	1м 1м 1м 1м	Дарцаг, цаг агаарын тэмдэгтэй нөөцөлсөн, тусгаарлах бүсийн тэмдэглэл
1.17		Чиг хөдлөх бүс
1.17		Чиг хөдлөх бүс

Тайлбар

Тусгайлан заасныгаас бусад хэмжээсийг м-ээр өгөв

Авто замын тэмдэг, тэмдэглэгээнд дараах стандартыг баримтлана

1 2.5мм зузаантай хөнгөнцагаан хаалт
2 Ø75мм ган тэнцэр шон
3 Гэрэл ойлгогч гэрэлгүй
4 Бүх зүй ёсны хаалгаагүй хаалгаар нийлсэн бөгөө бөгөө бүдүүг лентэй бүтээх
5 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2014
6 Авто замын тэмдэглэгээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759:2014

Замын босоо тэмдэг, тэмдэглэгээ



A	120
B	50
C	115
D	330
F	108
G	Ш18*22нүх
H	Ш25*64нүх

Туузан хашлага



Явган хүний замын хайс



No	Диаметр	Урт (mm)	Тоо хэмжээ	Нийт урт, /м/	Жин /кг.м/	Нийт жин /кг/
①	D8A-III	1292	6	7.75	0.395	3.06
②	D6A-I	440	4	1.76	0.212	0.37
③	D6A-I	251	3	0.75	0.212	0.16

No	Байрлал	Тоо хэмж. шир		Хоорондын зай
		Зүүн	Баруун	
1	ПК0+29.103	2	2	1т
Нийт		4		

Авто замын дохионы шон



Трассын төгсгөл дээрх уулзвар төлөвлөлт
/Авто замын зураг төслөөс үзэх/

4. ХУЧИЛТЫН ХИЙЦИЙН ТӨСӨЛЛӨЛТ

"INDOR PAVEMENT" хучилтын даацын программын тооцооны үр дүнгээс үзэхэд хучилтын даац, бат бэхийн үзүүлэлт, гузайлтын үзүүлэлтүүд нь шаардлага хангах түвшинд байна. Хучилтын тооцооны үзүүлэлтүүдийн нөөц нь хангалттай байна. Хучилтын хийцийн тооцооны үзүүлэлтүүдийг доор үзүүлэв.
Тооцоогоор төлөвлөсөн хучлагын бүтээц:

Өнгө асфальтбетон хучлага	3см	77см
Суурь асфальтбетон хучлага	4см	
Буталсан чулуун суурь	20см	
Хайрган дээд суурь	20см	
Хөлдөлтөөс хамгаалах үе	30см	

Хүснэгт 13 - Тооцоот өгөгдөл

Объектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажил		
Төлөвлөлтийн бүс нутаг	Орхон аймаг, Баян-Өндөр сум		
Хийгдсэн тооцооллууд	Уян харимхайн хотойлт, гулсалт, гузайлт, хөлдөлт		
Замын зэрэг	2А зэрэглэлийн зорчих хэсэг нь зааглагдаагүй, хөдөлгөөний 2 зурвастай хөдөө нутгийн хуримтлуулагч зам	Зурвасын өргөн, м	3.5
Замын хучилтын төрөл	Капитал	Хөрсний нягтын коэффициент	97%
Зурвасын тоо	2	Шаардлагатай уян харимхайн модуль, МПа	180
Тооцоолох зурвас /хөвөө талаас/	1	Тооцоот хугацааны турш ирэх стандарт ачаалал	1
Тооцоот чийглэг Wp	0.72	Тооцоот хурд, км/ц	60
Тэнхлэг ачаалал, кН /Дугуйн даралт, МПа/ Дугуйн мөр D, см	100/0.60/37	Жилд ашиглагдах өдрийн тоо	205

Найдвартай байдлын итгэлцүүр Кн	0.85	Ашиглалтын тооцоот хугацаа, жил	20
Зам цаг уурын бүс	IIA	Хөлдөлтийн гүн	3.45

Хучилтын хийц

1. Өнгө асфальтбетон – 3см
2. Суурь асфальтбетон – 4см
3. Буталсан чулуун суурь – 20см
4. Хайрган дэд суурь – 30см
5. Хөлдөлтөөс хамгаалах үе – 15см
6. Ул хөрс

Тооцооны схем



Хучилтын хийцийн тооцооны үзүүлэлт

№	Хучилтын нэр материалын хамт	Хучилтын хийц, Зузаан см	Уян харимхайн модуль, МПа	Хучилтын тооцооны үзүүлэлтүүд				
				Хотойлт, МПа	Гулсалт, МПа	Гулзайлт, МПа	Статик ачаалал	
Асфальтбетон хучилт	1.Өнгө асфальт бетон		Епов=288	Еупр=2400 Ктр=1.060 Красч=1.600 Запас=51%	Есдв=1200	Еизг=3600	Естат=480МПа	
	2 асфальт бетон		Епов=265	Еупр=1400	Есдв=800	Еизг=2200 Ктр=0.940 Красч=25.321 Запас=2594%	Естат=360МПа	
	3. Буталсан чулуун суурь		Епов=241	Еупр=450	Есдв=450	Еизг=450	Естат=450МПа	
	4. Хайрган дээд үе		Епов=155	Еупр=180	Есдв=180 Ктр=0.940 Красч=1.120 Запас=19%	Еизг=180	Естат=180 МПа Ктр=0.940 Красч=1.130 Запас=20%	
	5. Хөлдөлтөөс хамгаалах үе		Епов=144	Еупр=180	Есдв=180 Ктр=0.940 Красч=2.010 Запас=114%	Еизг=180	Естат=180 МПа Ктр=0.940 Красч=2.300 Запас=145%	
	Ул хөрс – Хайрагтай шаварлаг элс		Епов=108	Еупр=108	Есдв=108 Ктр=0.940 Красч=3.270 Запас=248%		Естат=108МПа Ктр=0.940 Красч=3.030 Запас=222%	Lдоп = 6 см Lпуч = 4 см Запас = 1 см

Анхны өгөгдөл
Объектын нэр: Орхон аймаг
Төсөл боловсруулах бүс: Орхон аймаг
Гүйцэтгэх тооцоонууд: Уян харимхайн хотойлт, шилжилт, гулзайлт, статик ачаалал
Зам-климатын бүс: II бүс – 2 дэд бүс
Чийгшлийн схем: Схем 1
Хөрсний тооцоот чийгшил Wp: 0.72
Хөрс нягтруулалтын коэффициент: 0.97
Замын бүтээцийн хөлдөлтийн гүн, м: 3.45
Уртын налуу i, ‰: 40.00
Төслийн өгөгдөл
Замын техникийн ангилал: IV зэрэг
Замын хучилтын төрөл: Хөнгөн хийцтэй
Тооцоот найдвартай байдал Кн: 0.85
Их засвар хоорондын ашиглалтын хугацаа: 20 жил
Зорчих хэсгийн өргөн: 8.0 м
Тооцоот ачаалал
Дугуйн доторх даралт p: 0.60 МПа
Дугуйн мөрийн диаметр (динамик): 37.10 см
Хөдөлгөөнгүй дугуйн штампын диаметр: 33 см
Тэнхлэг дээрх статик ачаалал Q: 100.00 кН
Ачаалал үйлчлэх нийт тоо: 400 000 удаа
Ачааллын нийт үйлчлэл
Ачааллын нийт үйлчлэлийн тоо: 1
Замын хэсгийн төрөл: Хөдөлгөөний эгнээ
Хөдөлгөөний эгнээний тоо (хоёр чиглэлд): 2
Захын хөвөөнөөс тооцоот эгнээний дугаар: 1
Жилийн тооцоот хоногийн тоо: 205
Эрчимжилтийн өөрчлөлтийн үзүүлэлт: 1.04

Хувилбар №1 – Замын хучилтын хийц ба тооцооны дүн
Хучилтын бүтэц
Өнгөн асфальтбетон хучилт – 3.0 см
Дайрга (хайрга) суурьтай А төрлийн хольцоор хийсэн, I маркийн нягт халуун асфальтбетон, битумын марк БНД / БН-90/130

Суурь асфальтбетон хучилт – 4.0 см
Том ширхэгтэй дайрга (хайрга) суурьтай, I маркийн сийрэг халуун асфальтбетон, битумын марк БНД-90/130

Буталсан чулуун суурь – 20.0 см
40–80 мм (80–120 мм) фракцтай, амархан нягтардаг буталсан чулуу, нарийн фракцтай дайргаар шаантагласан
Суурийн доод үе – 20.0 см
ГОСТ Р 71329-2024 стандартын дагуу элс-хайрганы хольц

Хөлдөлтөөс хамгаалах үе – 30.0 см
ПНСТ 403–2020 стандартын дагуу элс-хайрганы хольц

Суурийн хөрс – Хөнгөн шавранцар хөрс

Эдийн засгийн үзүүлэлт
Хувилбарын нийт өртөг: 7,700.00 нэгж
Төсөл хэрэгжих нийт талбай: 10,000 м² (10.0 × 1000)
Уян харимхайн хотойлтын тооцооны үр дүн
Гадаргын уян харимхайн модуль Епов = 288.4 МПа
Шаардлагатай уян харимхайн модуль Етр = 180.0 МПа
Тооцоот бат бэхийн коэффициент Красч = 1.600
Шаардлагатай бат бэхийн коэффициент Ктр = 1.060
Бат бэхийн нөөц = 51 %
Дүгнэлт: Замын хучилтын бүтээц нь бат бэх, хөлдөлтөд тэсвэртэй, норматив шаардлагыг бүрэн хангаж байна.
Шилжилтийн тогтвортой байдлын тооцоо
Суурийн доод үе ГОСТ Р 71329-2024 – Элс-хайрганы хольц
Дотоод үрэлтийн өнцөг φ = 45.0°
Наалдац сп = 0.030 МПа
Тооцоот гулсалтын хүчдэл Т = 0.031 МПа
Зөвшөөрөгдөх гулсалтын хүчдэл Тпр = 0.030 МПа
Тооцоот бат бэхийн коэффициент Красч = 1.120
Шаардлагатай коэффициент Ктр = 0.940
Бат бэхийн нөөц = 19 %
Хөлдөлтөөс хамгаалах үе ПНСТ 403-2020
Тооцоот бат бэхийн коэффициент Красч = 2.010
Шаардлагатай коэффициент Ктр = 0.940
Бат бэхийн нөөц = 114 %
Хөрс- Хөнгөн шавранцар
Тооцоот бат бэхийн коэффициент Красч = 3.270
Шаардлагатай коэффициент Ктр = 0.940
Бат бэхийн нөөц = 248 %
Нугаралтын бат бэхийн тооцоо
Нугралтад тэсвэрлэх чадвар Rn = 35.145 МПа
Хамгийн их суналтын хүчдэл σr = 1.388 МПа
Тооцоот бат бэхийн коэффициент Красч = 25.321
Шаардлагатай коэффициент Ктр = 0.940
Бат бэхийн нөөц = 2594 %

Статик ачааллын үеийн гулсалтын тогтворжилтын тооцоо
Доод суурийн үе: бат бэхийн нөөц = 20%
Хөлдөлтөөс хамгаалах үе: бат бэхийн нөөц = 145%
Хөрс: бат бэхийн нөөц = 222%
Хөлдөлтийн тэсвэр
Газрын доорх усны түвшин ≈5.0м
Хөлдөлтийн гүний өсөлт: 4.77см
Зөвшөөрөгдөх дээд хэмжээний 80%-иас бага байна.
Дүгнэлт: Бүтээц хөлдөлтөд тэсвэртэй байна.
Колейны тооцоо
Нийт колейн гүн: 0.8см
Зөвшөөрөгдөх гүн: 3.0см
Дээд хязгаар: 3.5см
Нөөц: 2.7см

5. ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, ТЕХНИКИЙН АЮУЛГҮЙН АЖИЛЛАГАА

Барилгын ажлыг гүйцэтгэх үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дараах хууль дүрэм стандартыг мөрдлөг болгоно.

1. Хөдөлмөрийн тухай хууль
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм ЗЗБНбД 15-002-2016

6.1 Ашиглах замын тэмдэг, тэмдэглэгээний төрөл, авах арга хэмжээ

Тээврийн хэрэгслийн жолооч болон унадаг дугуй/ мотоцикл/ердийн хөсөг унаж хөдөлгөөнд оролцогчид ажлын талбай дээрх замын тэмдэг болон техник хэрэгслүүдийн заалтыг мөрдөх үүрэгтэй. Энэхүү зорилгод хүрэхийн тулд замын Тэмдгүүд нь тээврийн хэрэгслийн жолооч болон унадаг дугуй/мотоцикл/ердийн хөсөг унаж хөдөлгөөнд оролцогчдод тодорхой, эргэлзээ төрүүлэхээргүй харагдах ёстой. Замын Тэмдгүүд нь тэмдэг тавих шаардлагад нийцсэн, зөвхөн ажлын хэрэгцээтэй үед тавигддаг байх ёстой. Жишээлбэл хэрвээ ажил өдөртөө дуусаад бүх ажилчид ажлаас буусан тохиолдолд "Зам барилгын ажилчид" гэсэн тэмдгийг буулгаж хураана.

Тээврийн хэрэгслийн жолооч болон унадаг дугуй/ мотоцикл/ердийн хөсөг унаж хөдөлгөөнд оролцогчдыг замын хөдөлгөөний менежментийн ажлыг дагаж мөрдүүлэхэд бүх хүчин чармайлтаа гаргах шаардлагатай. Замын хөдөлгөөнд оролцогчид болон жолооч нарт ажлын талбайг аюулгүйгээр хэрхэн яаж өнгөрөхөд тодорхой бөгөөд эргэлзээгүй мэдээлэл өгөхөд бүх анхаарлаа хандуулах шаардлагатай.

Зам барилгын ажлын талбай дээрх аюулгүй байдлын ажилтны үүрэг :

- Анхааруулах (анхааруулах Тэмдгүүд);
- Мэдээллэх (чиглэл заасан болон мэдээллэх Тэмдгүүд);
- Чиглүүлэх (хэвтээ тэмдэглэл, чиглүүлэх заалт хэрэгслүүд);
- Зохицуулах (замын хөдөлгөөний зохицуулагч, уулзварын зохицуулалт, зохицуулах тэмдэг
- Замын сүлжээний аюулгүй байдлыг өдөр тутам хангуулах ажлын хүрээнд хамгаалах (замын хажуугийн зурвасыг чөлөөтэй байлгах, хашилтууд хийлгэх гм) үүргийг гүйцэтгэх.

Зам барилгын ажлын талбай дээр замын хөдөлгөөний хяналт зохицуулалтанд ашигладаг бүх тэмдэг болон төхөөрөмжүүд нь дараах зориулалттай.

- Зам ашиглагч нарт зам барилгын ажил явагдаж байна гэдэг анхааруулга, заавар зөвлөгөөг өгнө
- Зам дээр эсвэл замын ойролцоо ажилчид болон тоног төхөөрөмж ажиллаж байгаа гэдгийг анхааруулж хэлнэ.
- Хурдыг тохиромжтой байдалд нь хянахад баталгаа болно.
- Зам ашиглагчид зөв зам сонгож явахад тусална.
- Ажлын бүс рүү зам ашиглагч нарыг нэвтэрхийг хориглоно. Энэ ажлын бүс дэх ажилчдын аюулгүй байдлыг хангаж өгдөг.
- Зам ашиглагч нарт зам барилгын ажлын бүс дуусаж байгааг мэдээлнэ.

Зам барилгын ажлын талбай дээр ашиглагдаж буй замын Тэмдгүүд нь хөдөлмөр хамгааллын шаардлагатай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах энгийн зааварчилгаа нь дараах агуулгатай байна:

- Нүдэнд үзэгдэхүйц – хялбархан харах боломжтой
- Тод – Унших боломжтой

- Ойлгомжтой – Ойлгох боломжтой
- Тохирсон – тухайн нөхцөл байдалд тохирсон
- Хоорондоо уялдаа холбоотой – улсын хэмжээнд бусад ижил төстэй нөхцөлтэй
- Зөв – ижил төстэй байгаад зогсохгүй зөв байх.

Барилгын ажлыг гүйцэтгэх үед ашиглах тэмдэгний төрлүүдийг дараах байдлаар харууллаа.

Барилгын ажлын үед ашигладаг зарим түгээмэл авто замын тэмдэгүүд



Ажлын талбай дээр ашиглагддаг олон мэдээллээр замын Тэмдгүүд нь дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай:

- Хосолмол мэдээлэл багтаасан самбарууд нь бие даасан тэмдгийн шаардлагатай ижил байх ёстой.
- Хүрээний бүх хэсгүүд нь зориулалтын дагуу мэдээлэлтэй байна.
- Хүрээний ашиглагдаагүй хэсэг байвал тэр зайнд нь хоосон шар өнгийн самбарыг ашиглаж болно.
- Хурдны хязгаарыг зохицуулах тэмдгийг ашиглах үед түүнд зориулсан самбарыг замын хөдөлгөөнтэй хамгийн ойр талд хүрээний дээд хэсэгт байрлуулна.
- Хэрвээ Тэмдгүүдийн бүрэлдэхүүнд хурдны хязгаарын самбар ороогүй бол 1,200 мм х 300 мм дэлгэц самбарыг хүрээний дээд хэсэгт эсвэл доод хэсэгт байрлуулна. Хамгийн чухал мэдээллийг тэмдгийн хамгийн дээд хэсэгт байрлуулах шаардлагатай.
- Замын тэмдэг болоод төхөөрөмжүүдийг шавар, тоос шороо, хир буртаг, болон бусад бохирдлоос салгаж цэвэрлэх шаардлагатай. Шаардлагатай бол тэднийг угааж цэвэр цэмцгэр хадгалах.
- Өдрийн гэрэлд гэрэл ойлгох чадваргүй болсон гандаж муудсан тэмдгүүдийг солино.
- Шөнийн цагаар Тэмдгүүд нь тодорч харагдах эсэхийг мэдэхийн тулд тэдгээрийн гэрэл ойлгох чадвараар нь шалгах. Удаан хугацааны ашиглалт эсвэл гадаргуун гэмтлийн улмаас муудсан гэрэл ойлгогчтой Тэмдгүүдийг солих шаардлагатай.

Зам барилгын ажлын талбай дээр замын аюулгүй байдлыг хариуцаж байгаа хянал зөвлөхийн ажилтан эсвэл аюулгүй байдлын ажилтан нь дараах зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай:

- Шөнийн цагаар ашиглах шаардлагагүй бүх тэмдгийг буулгах (ажил хийгдээгүй тохиолдолд).

- Тэмдгүүдийн бэхэлгээ сайн чанартай хийх, олон мэдээллийг нэг зэрэг өгч чадах Тэмдгүүдийн хувьд полимер хуванцар “core flute” материалаар хийсэн Тэмдгүүдийг хооронд нь холбож нэгтгэсэн байдлаар эсвэл Тэмдгүүдийг төмөр хүрээтэй нь бэхэлж гагнах шаардлагатай.
- Хуванцар, нийлэг гэх мэт аль болох хямд өртөгтэй материалаар хийсэн Тэмдгүүдтэй байхад анхаарах шаардлагатай.
- Тэмдэгнүүдийг нөхөн байрлуулахад зарцуулах тусгай төсөвтэй байх түүнийг бэлтгэсэн байх.
- Алга болсон эсвэл эвдэрсэн тэмдэгнүүдийг даруй орлуулахын тулд түгээмэл ашиглагддаг тэмдэгнүүдийн нөөцийг агуулахад хадгалж байх.

6.2 Ажлын хувцас болон хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах, замын хөдөлгөөний зохицуулагч ажиллах шаардлага

